



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/502

Арвайхээр

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, хүнсний худалдаа, үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, уст цэг, шатахуун түгээх станцын үйл ажиллагаанаас бусад нийтийн тээвэр, такси үйлчилгээ, боловсролын байгууллага, барааны зах, халуун ус, үзвэр үйлчилгээний байгууллагууд болон олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, сүм хийд, кино театр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газар, зочид буудал, баар, ресторан, зоогийн газруудын үйл ажиллагааг түр зогсоосугай.

3.Хүнсний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, уст цэгийн ажиллах цагийн хуваарийг 09:00-20:00 цаг хүртэл тогтоосугай.

4.Хүнсний худалдаа, эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, уст цэг, шатахуун түгээх станцын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний байгууллагуудыг эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрмийг чанд сахиж ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгүүлж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д тус тус даалгасугай.

5.Аймгаас гарах орох, сум хоорондох, баг хооронд эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс шатахууны тээврээс бусад бүх хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хориглосугай.

6.Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага болон Эрүүл мэндийн байгууллагаас бусад байгууллагын 0-5 насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхчүүдэд байгууллагын дотоод журмын хүрээнд цалинтай чөлөө олгож, ажилтан албан хаагч нарыг цахимаар ажиллуулах нөхцөл боломжоор хангаж ажиллуулахыг газар, хэлтэс, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад даалгасугай.

011101121

2.

7.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын цаг үеийн нөхцөл байдлын талаар ард иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлж, хүнсний бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөрөгдөлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох байгууллагын албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлэн зөрчлийг арилгаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (Д.Цэдэнбалжир)-т тус тус даалгасугай.

8.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 хүртэл хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Коронавируст (Ковид-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" А/500 дугаар захирамжийн 1, 2, 4, 5 дахь заалтыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ